



**Дорнод аймаг дахь
Төрийн аудитын газар**
Үндэсний Аудитын газрын нэгдсэн
төлөвлөгөө, удирдамжийн дагуу
хийсэн нийцлийн аудитын тайлан

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

ҮАГ-НАГ/2017/04-НА



**Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах хөрөнгөд
хяналт тавьж ажиллаагүй байна.**

Чойбалсан хот

2017 он

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын Нийцлийн
аудитын алба

Даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч
Б.Болортуул
Утас: 70584203

Аудитын менежерийн
үүргийг түр орлон
гүйцэтгэгч Д.Нармандах
Утас: 70584207

Ахлах аудитор
Ж.Баяртуул
Утас: 70584207

Аудитор
С.Энхбаатар
Утас: 70584207

2017 оны 08 дугаар
сарын 11

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207 дугаарын
утас, 70584203
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р
байр, 2 давхар 04 тоот

Товчилсон үгийн жагсаалт
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Үндсэн мэдээлэл

I Бүлэг. Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион
байгуулах хөрөнгийг холбогдох хууль,
журмын дагуу хуваарилж, зарцуулсан байна.

1.1.Ерөнхийлөгчийн сонгуулийн төсвийн зардлын
зүйлийг хуваарилахдаа орон нутгийн нөхцөл
байдалд тулгуурлаагүйгээс шатахууны зардлыг
бодит байдлаас дутуу тооцсон байна.

1.2.Сумдад Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион
байгуулах хөрөнгийг оновчтой төлөвлөж,
хуваарилсан байна.

1.3.Аймаг сумдын сонгуулийн хороод нь
батлагдсан төсвийг зориулалтын дагуу
зарцуулсан байна.

II Бүлэг: Сонгуулийн төсвийн хөрөнгийн
зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.

2.1. Аймаг, сумдын Сонгуулийн хороо сонгуулийн
төсвийн гүйцэтгэлийн тайланг журмын дагуу
тайлагнасан байна.

2.2.Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж
ажиллаагүй байна.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

ДҮГНЭЛТ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ

ЗӨВЛӨМЖ

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол Улс
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ОӨУБЕГ	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЗГ	Засгийн Газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
МТБ	Мэдээллийн технологийн бодлого

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны "Аудитын сэдэв батлах тухай" 02 дугаар тогтоол, МУ-ын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтыг шалгаж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ.Үүнд:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан эсэх.
2. Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьсан эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн Сонгуулийн хороо, сумдын сонгуулийн тойргийн хороодод, Цагдаагийн газар болон Улсын бүртгэлийн хэлтэст төсвөөс олгосон хөрөнгийн санхүүжилт, зарцуулалт, тайлагнал, хяналт шалгалтын баримт материалуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журам, МУЕА-ын баталсан аудитын төлөвлөгөөг баримтлан шалгадагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааг тайланд хавсаргав.

Үндсэн мэдээлэл

УИХ-аас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр шинэчлэн баталсан Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.3, 16.6 дахь заалтын дагуу Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг 6 дугаар сарын 26-ны өдөр явуулахаар товлон зарласан бөгөөд сонгуулийн зардлыг 15.7 тэрбум төгрөгөөр баталсан байна.

Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь заалтаар сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын төрлийг заасан бөгөөд СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих тайлан гаргах журмыг баталжээ.

Дорнод аймгийн Сонгуулийн хороо, сумдын 14 сонгуулийн хороо, 69 хэсгийн хороодод 260,3 сая төгрөгийг урьдчилан хуваарилсан байна.

Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 5 дахь заалтын дагуу СЕХ МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн анхан шатны санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч олонхын санал аваагүй тул 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн тогтоол гаргаж, хоёр дахь санал хураалт явуулах өдрийг 2017 оны 07 дугаар сарын 07-нд хийхээр товлож, ЗГ-ын 2017 оны 182 дугаар тогтоолоор дахин санал хураалтад шаардагдах зардлыг аймгийн Сонгуулийн хороонд СЕХ-оос 86,8 сая төгрөгийг нэмж хуваарилан санхүүжүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хороо нь Сонгуулийн тухай хуулийн 31.4¹ дэх заалтын дагуу 2017 оны 04-р сарын 12-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Дорнод аймгийн Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн тухай хуулийн 33.4² дэх заалтын дагуу 2017 оны 04-р сарын 20-ны өдрийн 2 дугаар тогтоолоор сумдын Сонгуулийн хороог 5-7 хүний бүрэлдэхүүнтэй, сумдын Сонгуулийн хороо нь Сонгуулийн тухай хуулийн 35.2³, 35.3⁴ дэх заалтуудын дагуу 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр хэсгийн хороог тус тус байгуулсан байна.

ОӨУБЕГ-аас аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст сонгогчдын нэрсийн жагсаалт үйлдэх, бүртгэх, цахим мэдээллийн санд байрлуулах, санал авах техник хэрэгслийг татаж авах, сумдын сонгуулийн хороонд хүргүүлэх, итгэмжлэгдсэн албан хаагчдын сургалт зохион байгуулах болон унаа, хоол, томилолтын зардалд 2 удаагийн санал хураалтад нийт 62,4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

ЦЕГ-аас аймгийн Цагдаагийн газарт санал авах байр болон саналын хуудас хүлээн авах, хүлээлгэн өгөх үеийн хамгаалалтад ажиллах цагдаагийн албан хаагчдын хоол, шатахуун, холбооны зардалд 2 удаагийн санал хураалтад нийт 11,4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

¹ Сонгуулийн төв байгууллага аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, нийт таваас есөн хүний бүрэлдэхүүнтэйгээр, санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө байгуулна.

² Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо сум, дүүргийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, нийт таваас есөн хүний бүрэлдэхүүнтэйгээр санал авах өдрөөс 65-аас доошгүй хоногийн өмнө байгуулна.

³ Санал авах байр нь ахлах зохион байгуулагч, зохион байгуулагч гэсэн орон тоотой, таваас долоон хүний бүрэлдэхүүнтэй байна.

⁴ Сум, дүүргийн сонгуулийн хороо нь санал авах байрыг санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө байгуулж, ахлах зохион байгуулагчийг томилно.

Аудитын шалгуур үзүүлэлт

Дараах хууль, эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн аудитын тухай хуулийн 15.1.15;
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 23 дугаар зүйлийн 23.2, 31 дүгээр зүйлийн 31.7, 31.8, 31.9, 31.10, 31.11, 31.15, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.6, 33 дугаар зүйлийн 33.13, 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.6, 36 дугаар зүйлийн 36.7, 38 дугаар зүйлийн 38.2,
- Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5, 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.14, 13.1.5, 13.3;
- СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоол;
- СЕХ-ноос батлан гаргасан бусад дүрэм, журам, заавар;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Болортуул удирдан, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, нийцлийн аудитын албаны ахлах аудитор Ж.Баяртуул, аудитор С.Энхбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитын талбарын ажлыг 07 дугаар сарын 25-наас, тайлагналын үе шатны ажлыг 08 дугаар сарын 06-наас эхлэн гүйцэтгэв. Тайлангийн нэгтгэлийг 2017 оны 08 дугаар сарын 10-ны дотор дуусгаж, үе шатны хяналтаар оруулж баталгаажуулан УАГ-ын НАГ болон холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь товчилсон үг, аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, үндсэн мэдээлэл, аудитын дүн, илрүүлсэн зөрчил, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 2 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч Дорнод аймгийн Сонгуулийн хорооны удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажууллаа.

I Бүлэг. Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу хуваарилж, зарцуулсан байна.

1.1 Ерөнхийлөгчийн сонгуулийн төсвийн зардлын зүйлийг хуваарилахдаа орон нутгийн нөхцөлд бодитой тулгуурлаагүйгээс шатахууны зардлыг дутуу тооцсон байна.

Дорнод аймгийн сонгуулийн хороонд Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын дагуу МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн 2 шатны санал хураалтын зардалд 347'116'000 төгрөг хуваарилагдсан байна. Үүнийг дараах байдлаар батлан ирүүлжээ. Үүнд:

- СЕХ-ны 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 295 дугаар албан бичгийн 2 дугаар хавсралтаар 260'298'000 төгрөг,
- Дахин сонгуулийн санал хураалтад 86'818'000 төгрөг,

СЕХ-оос төсөв хуваарилсан тухай бүрт зардал тус бүрийг зарцуулах зөвлөмжийг ирүүлсэн байна.

СЕХ-оос сонгуулийн зардлыг аймгуудын нутаг дэвсгэрийн хэмжээ, санал авах байрны хэсгийн хороодын алслалт зэрэгт тулгуурлаагүй бүх аймагт ижил жишгээр тооцон шатахууны зардлыг төлөвлөж, хуваарилж буй нь тус зардлыг тооцох арга, аргачлал байхгүйгээс зардлыг бодитой төлөвлөж, санхүүжүүлээгүй байна.

1.2. Сумдад Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг оновчтой төлөвлөж хуваарилсан байна.

Нийт 14 сумын хэсгийн хороодод 295'847'300 төгрөг буюу 76 хувь, аймгийн сонгуулийн хороонд 51'268'700 төгрөгийг буюу 24 хувийг зарцуулахаар тус тус хуваарилсан байна.

Сонгуулийн тухай хуулийн 23.2-д⁵ заасны дагуу санал авах хэсгийн хороог байгуулсан эсэхийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

№	Сумын нэр	Сонгогчийн тоо	Хэсгийн тоо	Анхан шатны сонгууль		Хоёр дахь шатны сонгууль	
				Төлөвлөөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөөгөө	Гүйцэтгэл
1	Баяндун	1'924	4	12'915'800	12'915'800	5'240'900	5'240'900
2	Баянтүмэн	1'597	4	12'375'800	12'375'800	5'040'900	5'040'900
3	Баян-Уул	2'878	5	15'381'400	15'381'400	6'288'200	6'288'200
4	Булган	1'190	4	12'465'800	12'465'800	5'020'900	5'020'900
5	Гурванзагал	895	3	10'320'200	10'320'200	4'073'600	4'073'600
6	Дашбалбар	2'031	5	15'521'400	15'521'400	6'458'200	6'458'200
7	Матад	1'766	6	19'300'500	19'300'500	7'709'500	7'709'500
8	Сэргэлэн	1'261	3	10'629'200	10'629'200	4'273'600	4'273'600
9	Халхгол	2'103	3	11'586'200	11'586'200	4'665'600	4'665'600
10	Хөлөнбуйр	1'187	2	8'418'600	8'418'600	3'306'600	3'306'600
11	Цагаан-Овоо	2'173	6	17'527'000	17'527'000	7'175'500	7'175'500
12	Чойбалсан	1'746	4	12'575'800	12'575'800	5'180'900	5'180'900
13	Чулуунхороот	1'207	3	10'830'200	10'830'200	4'283'600	4'283'600
14	Хэрлэн	28'321	17	41'871'400	41'871'400	15'410'000	15'410'000
15	Аймаг			48'578'700	48'578'700	2'690'000	2'690'000
	Нийт	50'279	69	260'298'000	260'298'000	86'818'000	86'818'000

Сонгуулийн тухай хуулийн дагуу 69 хэсгийн хороонд дундажаар 729 сонгогчтой, аймгийн төвийн 556 дугаар хэсгийн хороо нь хамгийн олон 2'394

⁵ Нэг хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төвд 2500-аас дээшгүй, нийслэлийн дүүрэгт 3000-аас дээшгүй сонгогчтой байна.

сонгогч, 558 дугаар хэсгийн хороо хамгийн цөөн буюу 556 сонгогч тус тус бүртгүүлсэн байна. Мөн сумдаас Баянтүмэн сумын 1362 дугаар хэсгийн хороо нь 775 сонгогч, Булган сумын 583 дугаар хэсгийн хороонд 169 сонгогч тус тус бүртгүүлжээ. Нийт 69 хэсгийн хороодыг байгуулахдаа аймаг, сумдын сонгуулийн хороо нь Сонгуулийн тухай хуулийн 23.2 дахь заалтыг мөрдөн ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хороо нь сонгогчийн тоо, санал авах хэсгийн хорооны тоо, газар нутгийн алслалт зэргийг харгалзан сонгуулийн зардлыг хуваарилсан байна.

1.3. Аймаг сумдын сонгуулийн хороод нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-оос хуваарилагдсан 347'116'000 төгрөгийг санхүүжилтээр авсан байна.

Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлыг аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн тухай хуулийн 38.2⁶ дахь заалтын дагуу зардлын ангилал тус бүрээр ангилсан байна.

Зардлын ангилалыг баталсан төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2

№	Зардлын нэр	Нэг дэх шатны сонгууль			Дахин сонгууль		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Сургалт	14'635'000	14'635'000	0	0	0	0
2	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх	100'000	100'000	0	0	0	0
3	Бичиг хэрэг	16'020'000	16'020'000	0	1'415'000	1'415'000	0
4	Шуудан холбоо	15'470'000	15'470'000	0	1'760'000	1'760'000	0
5	Унаа	28'300'000	29'300'000	-1'000'000	4'050'000	4'050'000	0
6	Сурталчилгаа	8'000'000	8'000'000	0	0	0	0
7	Сурталчилгааны материал хүргэх	1'750'000	1'750'000	0	0	0	0
8	Санал авах байр бэлтгэх	13'800'000	13'800'000	0	0	0	0

⁶ 38.2.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын сонгуулийн доор дурдсан сонгуулийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

38.2.1.сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны зардал;

38.2.2.нэр дэвшигчийн үнэмлэх, сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагч болон сонгуулийн ажиглагчийн үнэмлэх хэвлэх, хүргүүлэх зардал;

38.2.3.Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн хамгаалалтын зардал;

38.2.4.саналын хуудас хэвлүүлэх, хамгаалах, хүргүүлэх зардал;

38.2.5.сонгуулийн дүн, мэдээний маягт, бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчийн гарын үсэг цуглуулах маягт, сонгуулийн байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудас хэвлэх, хүргүүлэх зардал;

38.2.6.тамга, тэмдэг, лац, саналын хуудас битүүмжлэн хадгалах уут бэлтгэх зардал;

38.2.7.санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаанд хэрэглэх техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, программ хангамж, худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх, тээвэрлэх болон даатгал, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл, тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хамгаалах, хадгалах, засвар үйлчилгээ хийх, хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх, татан авах зардал;

38.2.8.санал хураалтын дүнгийн мэдээ дамжуулах зардал;

38.2.9.саналын хайрцаг хийх, хүргэх, санал авах байрын болон санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал;

38.2.10.сонгуулийн хууль тогтоомж болон сонгууль зохион байгуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын авлага, сургалт, сурталчилгааны материал боловсруулах, хэвлэх, хүргэх зардал;

38.2.11.сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал;

38.2.12.сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал;

38.2.13.сонгуульд нэр дэвшүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт, зарцуулалтыг хянан шалгахад гарах зардал;

38.2.14.нэмэлт болон дахин санал хураах, ээлжит, ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль явуулах зардал;

38.2.15.сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн болон ажлын хэсгийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал;

38.2.16.сонгуулийн байгууллагын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал;

38.2.17.гадаад улсад байгаа иргэдийн санал авахтай холбогдон гарах зардал;

38.2.18.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;

38.2.19.сонгуулийг зохион байгуулахтай холбогдсон бусад зардал.

9	Саналын хуудас хүргэх	4'432'000	4'432'000	0	3'554'000	3'554'000	0
10	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах	10'342'000	10'342'000	0	7'256'000	7'256'000	0
11	Мэдээ дамжуулах	3'525'000	3'525'000	0	3'525'000	3'525'000	0
12	Томилолт	4'318'000	4'318'000	0	0	0	0
13	Эрчим хүчний үүсгэвэр бэлтгэх	4'898'000	4'898'000	0	2'898'000	2'898'000	0
14	Болзошгүй зардал	1'000'000	0	0	0	0	0
15	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоол	110'724'800	110'724'800	0	10'360'000	10'360'000	0
16	МТБ-ийн гишүүний, даамлын ураашуулал, хоол	23'253'200	23'253'200	0	52'000'000	52'000'000	0
	Нийт	260'298'000	260'298'000	0	86'818'000	86'818'000	0

Аймгийн сонгуулийн хорооноос 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 05 тоот “болзошгүй зардлын 1,0 сая төгрөгт зохицуулалт хийх” хүсэлтийг СЕХ-д хүргүүлсэн байна. СЕХ нь 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 16 дугаар тоот албан бичигтээ “болзошгүй зардлын 1,0 сая төгрөгийг унааны зардалд шилжүүлж болох тухай” дурьдсны дагуу аймгийн сонгуулийн хороо төсөвт орсон өөрчлөлтийн дагуу зарцуулсан байна.

Бодит гүйцэтгэлээрх шатахууны дутагдал 3,8 сая төгрөгийн зардлын 1,0 сая төгрөгийг СЕХ-оос зрхицуулж өгсөн боловч 2,8 сая төгрөгийн өр үүсэх нөхцөл байдал бий болсныг сумдын шатахууны зардлаас санхүүжүүлэхээр шийлвэрлэсэн байна.

Аймгийн сонгуулийн хорооны төрийн сан дахь 100070022001 тоот дансанд үлдэгдэлгүй байна.

Сонгуулийн зардлын гүйцэтгэлд аудит хийхэд сонгууль зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай уртасгагч, плаш, принтерийн бултай хор, тооны машин зэрэг нийт 4'081'924 төгрөгийн дахин ашиглах боломжтой хангамжийн материалыг 12 сумдын сонгуулийн хороо нь шууд зардалд бүртгэснийг сумдын ЗДТГ болон багийн ажлын албанд өгч данс бүртгэлд тусгуулж ажиллаагүй байна.

Дээрхийг эс тооцвол аймаг, сумын сонгуулийн хороо нь “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын дагуу батлагдсан төсвийг зарцуулсан байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь анхан шатны баримтыг бүрэн хангаагүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна.

Сонгуулийн тухай хуулийн 38.3⁷-д заасны дагуу ОӨУБЕГ-аас аймгийн Улсын

⁷ Сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, улсын бүртгэлийн байгууллагын төсөвт тусгана:

38.3.1.сонгогчдыг бүртгэх, тэднийг таньж оруулах техник хэрэгсэл, сэлбэг, программ хангамж, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл, тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээг хийх, хэвлэх, тээвэрлэж хүргүүлэх, татан авах болон түүнтэй холбогдсон бусад зардал;

38.3.2.сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, түүнийг цахим хуудаст байрлуулах, түүний программ хангамж, түрээс, хэвлэх, хүргэх, мэдээлэл, сурталчилгаа явуулах, түүнтэй холбогдсон бусад зардал;

38.3.3.улсын бүртгэлийн байгууллагын ажилтан болон итгэмжлэгдсэн ажилтны зардал, мөнгөн урамшуулал, хоол, унааны зардал;

38.3.4.улсын бүртгэлийн байгууллагын ажилтан болон итгэмжлэгдсэн ажилтны сургалт зохион байгуулах, түүнтэй холбогдсон бусад зардал;

бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн 100070012420 тоот дансаар дамжуулан эхний шатны санал хураалтын зардалд 43'653,3 мянган төгрөгийн, 2 дахь шатны санал хураалтын зардалд 18'738,0 мянган төгрөгийн нийт 62'391,2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

№	Зардлын нэр	23'676.3	Нэг дэх шатны			Дахин сонгууль	
		сонгууль					
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Бичиг хэрэг	3'500'000	3'500'000	0	1'231'400	1'231'400	0
2	Томилолт, шатахуун, шуудан	10'602'900	10'602'900	0	7'007'300	7'007'300	0
3	Итгэмжлэгдсэн ажилтны цалин, хоол	23'676'300	23'676'300	0	10'499'300	10'499'300	0
4	Хурууны хээ унших машин авч ирэх хүргэх зардал	5'874'000	5'874'000	0			
	Нийт	43'653'200	43'653'200	0	18'738'00	18'738'00	0

Аудитаар аймгийн УБХ-ийн сонгуулийн зардлын гүйцэтгэлийг тулган баталгаажуулахад анхан шатны баримтгүй дараах 1'825.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгасан байна.

Шатахуунд 2 удаа 1'325.0 мянган төгрөг, Замын зардлын 500,0 мянган төгрөгийг тус тус баталгаажсан төлбөрийн баримтгүйгээр, зөвхөн нэхэмжлэх үндэслэн шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7⁸ дахь, 20.1.4⁹ дэх заалтуудтай нийцэхгүй байна.

Аймгийн Цагдаагийн газар нь сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Сонгуулийн тухай хуулийн 38.4¹⁰ -д заасны дагуу ЦЕГ-аас аймгийн Цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн 100070012401 тоот нэмэлт орлогын дансаар дамжуулан санал авах байр, сонгуулийн тоног төхөөрөмж болон саналын хуудас хүлээж авах, хүлээлгэн өгөх үеийн хамгаалалтад ажиллах цагдаагийн алба хаагчдын хоол, шатахуун, холбооны зардалд 2 удаагийн санал хураалтад нийт 11'542.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4

№	Зардлын нэр	Нэг дэх шатны сонгууль			Дахин сонгууль		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Шатахуун	1'200'000	1'200'000	0	1'200'000	1'200'000	0

38.3.5.сонгогчдыг бүртгэх, санал авах техник хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын ажилтны томилолт, унааны зардал, техник тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий мэдээлэл технологийн шуурхай багийн мөнгөн урамшуулал, хоол, унааны зардал;

38.3.6.нэмэлт болон дахин санал хураах, ээлжит бус болон дахин сонгууль явуулах тохиолдолд улсын бүртгэлийн байгууллагаас гаргах зардал;

38.3.7.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал.

⁸ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно

⁹ хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх

¹⁰ Сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, цагдаагийн байгууллагын төсөвт тусгана:

38.4.1.санал авах байрын хамгаалалт, шатахуун, техник хэрэгслийн зардал;

38.4.2.цагдаагийн албан хаагчийн томилолт, мөнгөн урамшуулал, хоолны зардал.

2	Холбоо	584'000	584'000	0	848'00	848'000	0
3	Хоол	0	0	0	7'710'000	7'710'000	0
	Нийт	1'784'000	1'784'00	0	9'758'000	9'758'000	0

Аймгийн Цагдаагийн газар нь ЦЕГ-аас олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

II Бүлэг. Сонгуулийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.

2.1. Аймаг, сумдын Сонгуулийн хороо сонгуулийн төсвийн гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу сумдын сонгуулийн хороод нь сонгуулийн төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган ирүүлж, аймгийн сонгуулийн хороонд нэгтгүүлсэн байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороод нь Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн үдэж цэгцэлсэн нь Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4.1 дэх “Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, ...” гэж заасантай нийцэж байна.

2.2. Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.

Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.4-д “..., аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд тус тус хяналт тавина.” гэж заасны дагуу аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.

Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумдын сонгуулийн хороонд тухай бүр нь төсвийн задаргаа болон зөвлөмжийг хүргүүлж ажилласан боловч хяналт хийсэн тухай ажлын тайлан материал байхгүй байна.

Аймгийн сонгуулийн хороонд Баяндун, Дашбалбар сумаас бусад сумд сонгуулийн төсвийн гүйцэтгэлийн тайланг албан бичгээр хүлээлгэж өгөөгүй, бүх сумдын сонгуулийн хороо тайлангийн товч танилцуулга, тодруулгыг тус тус ирүүлээгүй байна. Энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4.3-д “Сум, дүүргийн сонгуулийн хороо болон салбар комиссын сонгуулийн зардлын тайлан дараах хэсгээс бүрдэнэ;”, 4.3.1-д “сонгуулийн зардлын тайлан өгөх тухай албан бичиг;”, 4.3.2-д “тайлангийн товч танилцуулга, тодруулга;” гэсэн заалттай нийцэхгүй байна. Эндээс үзэхэд аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны тайланг журмын дагуу хянаж хүлээн аваагүйг харуулж байна.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт 9,7 сая төгрөгийн дараах зөрчлийг илрүүллээ. Үүнд:

- Шатахууны зардлыг бодитой тооцож, төлөвлөн санхүүжүүлээгүйгээс 3,8 сая төгрөгийн шатахуун бодитоор дутсан байна.
- Дахин ашиглах боломжтой 4,1 сая төгрөгийн хөрөнгийг шууд зардалд

бүртгэсэн, 1,8 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл хангаагүй гүйлгээг бүртгэсэн.

- Сумдын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, журмын дагуу хянаж хүлээн аваагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Сонгуулийн ерөнхий хороо нь төсвийн зардлын зүйлийг хуваарилахдаа нутаг дэвсгэрийн хэмжээ, санал авах хэсгийн хорооны алслалт зэрэгт тулгуурлан шатахууны зардлыг тооцох арга, аргачлал байхгүй байна.
2. Дахин ашиглах боломжтой нийт 4'081'924 төгрөгийн бичиг хэрэг, хангамжийн материалыг 12 сумдын сонгуулийн хорооны шууд зардалд бүртгэсэн байна.
3. Сумдын сонгуулийн хорооны төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.
4. Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны тайланг журмын дагуу хянаж хүлээн аваагүй байна.
5. Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 1'825'000 төгрөгийн анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

ҮАГ-аар уламжлуулан Сонгуулийн ерөнхий хороонд:

1. Сонгуулийн ерөнхий хороо нь төсвийн зардлын зүйлийг хуваарилахдаа нутаг дэвсгэрийн хэмжээ, санал авах хэсгийн хорооны алслалт зэрэгт тулгуурлан шатахууны зардлыг тооцох арга, аргачлалтай болох.

Аймгийн Сонгуулийн хорооны дарга П.Бат-Өлзий, нягтлан бодогч Ц.Амгаланзаяа нарт:

1. Дахин ашиглах боломжтой хангамжийн материалыг бүртгэлд тусгуулан ажиллах.
2. Сумдын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, журмын дагуу хянаж хүлээн авах.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Оюунбаярт:

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу 1'635'000 төгрөгийн ажил, гүйлгээний баримтын бүрдлийг ханган ажиллах.





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 08 сарын 11 өдөр

Дугаар 15

Чойбалсан хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121, 2016 оны А/146 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, Аймгийн сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Ж.Баяртуулд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.БОЛОРТУУЛ

11 104